



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 10 сарын 4 өдөр

Дугаар 2606/05

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Адаацаг сумын 2024 оны мал хамгаалас сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд нярав Ч.Урантуяагийн хувийн данснаас малчдаас өвс, тэжээлийн үнэ болох 17,563.2 мянган төгрөг мал хамгаалах сангийн дансанд тушаагдсан байна. Тухайн орлого няравын дансанд хэн тушаасан, хэзээ орсон, хэдэн тэжээл, өвсний үнэ болох нь тоо, ширхэг, үнийн дүнгээр задаргаагүй, хэд хоног хадгалагдсан нь тодорхойгүй, тухайн данснаас 3,158.0 мянган төгрөгийн тээврийн хөлсийг анхан шатны баримтад үндэслээгүй зарцуулсан, бүртгэлд тусгаагүй тайлагнасан зөрчил илэрсэн.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Нэг. "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг; 14 дүгээр зүйлийн 14.4.4.аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр; 14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал; гэсэн заалтын дагуу хууль, журмыг мөрдөж, зөрчлийг арилгах, хувийн дансаар төлбөр тооцоо хийхийг таслан зогсоох, нягтлан бодох бүртгэлийг залруулан үнэн зөв тайлагнаж ажиллахыг Засаг Дарга Ч.Уранчимэг, нягтлан бодогч Ө.Уранбилэг, нярав Ч.Урантуяа нарт даалгав.

Хоёр. Энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

Гурав. Албан шаардлагын хэрэгжилтийг 2024 оны 11 дугаар сарын 02-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд бичгээр ирүүлэх.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ С.БАРХАСМАА

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ С.ЗООМОН  
С.ЭНХТАЙВАН  
С.ТҮВШИНЖАРГАЛ

ХҮЛЭЭН АВСАН:

АДААЦАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ Ө.УРАНБИЛЭГ  
НЯРАВ Ч.УРАНТУЯА